

Дундговь аймаг дахь цагдаагийн газар

139. АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ
АЖИЛЛАГАА

Баталсан 2017-12-20
А/246

Сургалт зохион байгуулсан: Хүний нөөцийн
мэргэжилтэн, цагдаагийн ахмад Б.Батцэцэг

139.1.ЗОРИЛГО

- Авлигаас урьдчилан сэргийлэх цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагааны дотоод дэг горимыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

• 139.2.ХАМРАХ ХҮРЭЭ, БАРИМТЛАХ БОДЛОГО

- 139.2.1.Цагдаагийн төв байгууллага, алба, нэгж,дотоодын цэргийн штаб, анги, тусгай салбар,нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, алба хаагч нар үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

- 139.2.2. Авлигаас урьдчилан сэргийлэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Авлигын эсрэг хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Дотоодын цэргийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад холбогдох хууль, Авлигын эсрэг хөтөлбөр, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн актыг үйл ажиллагаандаа баримтална.

- 139.3.НЭР ТОМЬЁО

- Энэ журамд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

“Авлига” албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг;

“Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” авлигын шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, тэдгээрийг арилгах, авлигыг таслан зогсооход чиглэгдсэн арга хэмжээний цогцолборыг;

“Олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа” олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, уг ажиллагаанд тэднийг татан оролцуулах арга хэмжээний цогцолборыг;

“Эрх бүхий албан тушаалтан” – байгууллагын хэмжээнд алба хаагчдын хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, тайлагнах ажлыг шууд хариуцсан зохион байгуулж буй алба хаагчийг.



139.4.4.Цагдаа, дотоодын цэргийн байгууллага нь авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:


- а/цагдаагийн төв байгууллагын дарга нь авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтанг томилж, ажиллуулах;
- б/цагдаагийн төв байгууллагын болон харьяа алба, нэгжийн эрх бүхий албан тушаалтнууд нь авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах, зөвлөгөө өгөх;

139.4.4.Цагдаа, дотоодын цэргийн байгууллага нь авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:

- в/Мэдээллийн ил тод байдлыг хангах /код 135/ журам"-д заасан ил тод байдлыг хангах мэдээллийн бүтэц, товд заасан хугацаанд гадаад болон дотоод цахим хуудсанд холбогдох мэдээ мэдээллийг байршуулах;
- г/цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтан бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, эрхэлж байгаа ажил үүргийн онцлогтой холбогдуулан хориглох зүйлийг Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хуульд заасны дагуу тогтоон мөрдүүлэх
- д/бүрэн эрхийнхээ хүрээнд авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах арга хэмжээ авах;

139.4.4.Цагдаа, дотоодын цэргийн байгууллага нь авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:

- е/цагдаа, дотоодын цэргийн алба хаагч нь үүргээ гүйцэтгэж байх явцдаа олж мэдсэн алба хаагчийн авлигатай холбоотой асуудлыг Авлигатай тэмцэх газар, цагдаагийн төв байгууллагын Аюулгүй байдал хариуцсан нэгжид мэдээлэх;
- ж/авлига гарах нөхцөл бүрдсэн гэж үзсэн тушаал, шийдвэрийг эрх бүхий этгээдээс өгсөн саналын дагуу хянан үзэн хүчингүй болгох буюу өөрчлөх;
- з/хууль тогтоомжид заасан бусад



139.4.5.Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын дарга, эрх бүхий албан тушаалтан нь дараахь эрх, үүрэгтэй:

- а/цагдаа, дотоодын цэргийн байгууллага бүх шатны дарга нь алба хаагчдыг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, цагдаагийн төв байгууллагын тушаалаар томилогдсон эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих;

139.4.5.Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын дарга, эрх бүхий албан тушаалтан нь дараахь эрх, үүрэгтэй:



б/эрх бүхий албан тушаалтан нь: -Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулах, үр дүнг тооцох ажлыг зохион байгуулж, Авлигатай тэмцэх газарт тайлагнах;

-цагдаагийн байгууллагын авлигаас урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн төлөвлөгөө, түүний биелэлтийг тооцож, дүнг цагдаагийн төв байгууллагын удирдлага, Авлигатай тэмцэх газарт тайлагнах;

- цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдүүлсэн Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг засваргүй, бүрэн гүйцэд бөглөгдсөн, хугацаандаа өгсөн эсэхэд хяналт тавьж, мэдүүлгийг зохих журмын дагуу гаргаж өгөхийг шаардах, хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл байвал албаны шалгалт явуулах, эсхүл цагдаагийн төв байгууллагын Аюулгүй байдал хариуцсан нэгжид шилжүүлэн шалгуулах.

в/алба хаагч, ажилтан нь:



- Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, Цаашид тухайн алба хааж байгаа хугацаандаа шинэчлэн гаргах жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргах, мэдүүлэг гаргагч нь өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй.



- Хөрөнгө, орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол түүнийг тухай бүр мэдүүлэх. /30 хоногийн дотор/
- Гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн хүнээс бусад этгээдээс авсан нэг удаагийн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны нэг сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн, эсхүл нэг эх сурвалжаас нэг жилийн туршид хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны гурван сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд уг албан тушаалтан энэ тухай эрх бүхий албан тушаалтанд бичгээр мэдэгдэх /30 хоногийн дотор/

**140. АШИГ СОНИРХЛЫН
ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ**



140.2.ХАМРАХ ХҮРЭЭ, БАРИМТЛАХ БОДЛОГО

- 140.2.1.Цагдаагийн төв байгууллага, алба нэгж, дотоодын цэргийн штаб, анги, тусгай албар, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, алба хаагч нар үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.



- г/захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх оролцохын өмнө ашиг сонирхлын зөрчилгүй гэсэн мэдэгдэл гаргаж, эрх бүхий албан тушаалтанд бичиг /Монгол Улсын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийн дагуу/-ээр гаргаж, танилцуулах;



- д/алба хаагчид хууль сахиулах чиг үүргээ хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл цагдаагийн төв байгууллагын Аюулгүй байдал хариуцсан нэгжид Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 139-т заасан маягт /ЦБҮАЖ No139.61в/-ын дагуу мэдэгдэж, шалгуулах;

- е/албан үүрэгтэй нь холбогдуулан аливаа этгээд бэлэг, үйлчилгээ, ашигтай нөхцөл байдлыг санал болгосон тохиолдолд татгалзаж, уг этгээдийг тодорхойлох, бэлэг өгсөн талаар удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагад мэдэгдэж, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 139-т заасан маягт /ЦБҮАЖ No139.61в/-ын дагуу баримтжуулах;

140.4.АЛБА ХААГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 140.4.1.Алба хаагч нь удирдах албан тушаалд томилогдохын өмнө холбогдох хууль тогтоомжид заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй тухай урьдчилсан мэдүүлгийг гаргаж эрх бүхий албан тушаалтанд өгнө.
- 140.4.2.Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын удирдлагаар томилогдох тохиолдолд тухайн газарт түүнтэй хамаарал бүхий этгээдээс аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг эсэхийг мэдэгдэх бөгөөд томилогдсоноос хойшхи хугацаанд мэдсэн тохиолдолд энэ тухай цагдаагийн төв байгууллагын Аюулгүй байдал хариуцсан нэгжид мэдэгдэнэ.



Анхаарал
хандуулсанд
баярлалаа

